

Монгол Улсын Их Хурлын Хууль
зүйн байнгын хорооны 2026 оны ...
дугаар сарын ... -ны өдрийн
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Баатарсүрэн Ургийн овог: Чанрав Нэр: Оюунгэрэл Хүйс: Эм Төрсөн он: 1985 он [REDACTED] Төрсөн газар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа,

	эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.6	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.8	Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
	Үгүй

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/ Нэр дэвшсэн үндэслэл: Миний бие Б.Оюунгэрэл нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 74-р цэцэрлэгт хүмүүжиж, Мишигийн Цэдэндоржийн нэрэмжит гадаад хэл, урлагийн төрөлжсөн сургалттай 50 дугаар дунд сургуулийг төгссөн. Улмаар хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч, бакалавр мэргэжлээр төгсөж, улсад 16 жил, төрийн албанд 14 жил үүнээс шүүхийн салбарт 11 жил 08 сар тасралтгүй ажиллаж байна. Энэхүү шүүх эрх мэдлийн салбарт Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны төв байгууллага буюу Шүүхийн ерөнхий зөвлөлд Зохион байгуулагчаас эхлээд, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, Шүүгчийн туслах, Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, Бодлого төлөвлөлт, Хууль зүйн асуудлыг тус тус хариуцан гардан ажиллаж шүүхийн шүүн таслах ажиллагааны болон шүүхийн захиргааны мэдлэг, туршлага хуримтлуулсан, төрийн албаны мерит зарчмын дагуу дэвшсэн, мэргэшсэн төрийн жинхэнэ албан хаагч юм.
------------	---

Шүүх нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын дархлаа, үндэс болсон, төр, шударга ёсонд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэгч, шударга ёсны төрийн үйлчилгээ үзүүлэгч болохын хувьд шүүхийн захиргаа нь шүүх, шүүгчийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажлыг хэвийн тасралтгүй явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх, шүүхийг хүний нөөцөөр шуурхай хангах, сургах, эдийн засгийн баталгааг хангуулах, нээлттэй, ил тод байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Өнгөрсөн хугацаанд буюу 2016 оноос хойш миний бие Шүүхийн ерөнхий зөвлөлийн 3 удаагийн бүрэлдэхүүн, ажлын албаны удирдлагуудаас тухай бүр суралцаж ирсэн бөгөөд шүүх эрх мэдлийн салбарын шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, шүүх эрх мэдлийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх, өмнөх хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг үнэлэх, шинээр боловсруулах, батлуулах ажилд тогтвортой, туушдаа, үр дүн гаргаж, гар бие оролцож ирсэн туршлага минь цаашид илүү их үр бүтээлтэй ажиллахад давуу тал болно гэж үзэж байна.

Иймд шүүхийн салбарт ажиллаж байгаа өөрийн туршлага, мэргэжил, мэргэшилд үндэслэн шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүхийн үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна:

Хийх ажил:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт заасны дагуу анхдагч “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрэм”-ийг боловсруулах, батлуулах.

2. Шүүхийн үйлчилгээг доголдуулж байгаа, иргэдэд үзүүлэх шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, шударга, чанартай хүргэхэд хүндрэл учруулж байгаа болон эдгээрээс шалтгаалан шүүхэд итгэх иргэдийн итгэлийг буурахад сөргөөр нөлөөлж буй эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн тулгамдаж буй зарим давхардал, хийдэл, зөрчлийг судлах, тодорхойлох, тэдгээрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах, хамтран ажиллах, бодит үр дүнд хүргэх.

3. Шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үндсэн чиг үүргийг биелүүлдэг шүүхийн захиргааг Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн бэхжүүлэх, хөгжүүлэх, хараат бус байдлыг хангах, боловсронгуй болгох,

4. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, залгамж чанарыг хадгалах.

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</p> <p>-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> -Хаяг: Чингэлтэй дүүрэг, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр, -ажилласан хугацаа: 1 жил 6 сар, -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Шүүхийн бие даасан байдлыг болон мэдээллээр хангах, Шүүх эрх мэдлийн хүрээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, төсөл боловсруулах, хууль зүйн асуудлаар бодлого, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу арга зүйн зөвлөгөөгөөр хангах, захиргааны хэм хэмжээний акт, шүүхийн захиргааны дүрэм, журмын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэжлэг үзүүлэх, хууль зүйн дүгнэлт, лавлагаа гаргах, хэлтсийн ажлыг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн удирдлагын өмнө хариуцан тайлагнана. -Шууд удирдлага: Захиргаа, удирдлагын газрын дарга Л.Санжрагчаа, sanjragchaa@judcouncil.mn/ -Хамт ажиллаж байсан: 2024 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байсан Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх шүүгч Л.Энхбилэг, [REDACTED] -Хуулийн төслийн чиглэлээр хамтран ажилладаг: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, [REDACTED] -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Эрдэнэбулган, [REDACTED] -Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм, хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон, [REDACTED] -Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга [REDACTED] -Одоо хамт ажиллаж байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод ажил хариуцсан ахлах шинжээч Б.Золзаяа, [REDACTED] <p>-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Захиргаа, удирдлагын газрын Бодлого, төлөвлөлт хариуцсан референт, ахлах референт:</p> <ul style="list-style-type: none"> -Хаяг: Чингэлтэй дүүрэг, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр, -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг хангах, холбогдох арга хэмжээ авах, түүнд үндэслэн шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох санал, хувилбар боловсруулах, харьяалах чиглэлээр шүүхийн Тамгын газарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн удирдлагын өмнө хариуцан тайлагнана. -Шууд удирдлага Захиргааны удирдлага, бодлогын газрын дарга

байсан: Шууд удирдлага: Ж.Сайнхишиг, [REDACTED]
sainkhishiq115@gmail.com

-Хамт ажиллаж байсан: Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны дарга байсан Р.Онончимэг, [REDACTED]

-Бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллаж байсан Удирдлагын академийн Ахлах багш Ё.Батсүх, [REDACTED]

-Монгол банкны ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, 95900625,

-Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газрын дарга Т.Түвшинбаяр, [REDACTED]

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Захиргаа, удирдлагын газрын Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээ хариуцсан референт:

-Хаяг: Чингэлтэй дүүрэг, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр,

-Шууд удирдлага Захиргааны удирдлага, бодлогын газрын дарга байсан: Шууд удирдлага: Ж.Сайнхишиг, [REDACTED]
sainkhishiq115@gmail.com

-Хамт ажиллаж байсан:

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Т.Мэндсайхан [REDACTED]

-Хууль зүйн асуудал хариуцсан референт М.Түмэнцэцэг, [REDACTED] одоо УИХ-ын тамгын газрын ахлах референт,

-Шүүхийн сахилгын хорооны Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Алтаншагай, [REDACTED]

-Эвлэрүүлэн зуучлагч хариуцсан референт /одоо өндөр насны тэтгэвэрт/ Р.Ичинхорлоо, [REDACTED]

-Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Зохин байгуулагч, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, Шүүгчийн туслах:

-Монгол Улс Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг Баруун Сэлбийн гудамж шүүхийн байр, И-мэйл: n_dawakh_tg@shuukh.mn

-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:

Шүүгчийн туслах: Магадлалын төсөл бэлтгэх, шүүх хуралдаанд бэлтгэх, шүүгчид техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэргийн оролцогчидтой харилцах,

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: шүүх хуралдааны тэмдэглэл бичих, шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүгчийн туслахад туслах.

Зохион байгуулагч: Цагдах хорих 461 дүгээр ангид давж заалдах шатны шүүхийн магадлалыг шүүгдэгч, хоригдогчид гардуулан өгч тэдгээрийн хяналтын шатны шүүхэд хандах зэрэг эрхийг тайлбарлан, баримт дээр гарын үсэг зуруулах, шүүх хуралдааны бэлтгэл хангах, Ерөнхий шүүгч, шүүхийн Тамгын газрын дарга, хүний нөөцийн ажилтан,

	<p>Ерөнхий шүүгчийн туслахаас өгсөн чиглэлийн дагуу шүүхийн байр, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, шүүхийн үйлчилгээ, архивын үйлчилгээнд туслах чиг үүргийг гүйцэтгэх, бүртгэлийн дэвтэр хариуцах зэрэг.</p> <ul style="list-style-type: none"> -Шууд удирдлага байсан: -Шүүгч байсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Зориг, [REDACTED] -Ерөнхий шүүгчийн туслах байсан Н.Мөнхгэрэл, [REDACTED] Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга, -Хамт ажиллаж байсан: <p>Шүүгчийн туслах байсан одоо Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн тойргийн шүүхийн шүүгч М.Түмэннаст, [REDACTED]</p> <ul style="list-style-type: none"> -Шүүгчийн туслах А.Дуламсүрэн, [REDACTED] <p>-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргааны хэлтсийн ажилтан:</p> <ul style="list-style-type: none"> -Төрийн ордон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 2 дугаар давхар, -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Бичиг хэргийн ажилтан. <p>Засгийн газарт болон Хэрэг эрхлэх газарт гаднын байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг программд оруулах, удирдлагын цохолтыг оруулах, цохолтын дагуу ажилтнуудад хуваарилах, хариу бичигт дугаар олгох, архивлах, албан бичгийг яам, Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагуудад хүргүүлэх, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолыг албажуулах, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэх зэрэг.</p> <p>-Нийгмийн даатгалын дэвтрээр тодорхойлогдоно. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архивт ажилд орсон, гарсан тушаалууд хадгалагдаж байгаа.</p> <ul style="list-style-type: none"> -Шууд удирдлага байсан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар Ш.Солонго дарга, Захиргааны хэлтсийн даргаар Б.Доньжчимбуу, Хүний нөөц референтээр Н.Алтанцэцэг ажиллаж байсан. -Хамт ажиллаж байсан: Ш.Цэцэг-Өлзий, одоо мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Боловсролын яам хариуцсан референтээр ажилладаг, -Ерөнхийлөгчийн Тамгын газрын Шагналын Тасгийн дарга Ө.Мөнгөнцэцэг.
<p>3.2</p>	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил</p> <p>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p>
	<p>“Шүүдэр продакшн” ТББ-т Ерөнхий менежерийн албан тушаалд 2 жил ажиллахдаа “Ану хатан” кино төсөл, “Улаан пальто” кино төсөлд тус тус гэрээ байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, кино төслийн ерөнхий</p>

	<p>менежер, туслах жүжигчин, гүйцэтгэх продюсероор тус тус ажилласан. Мөн “Ану хатан” хүүхдийн зурагт комик номын анхны хэвлэлийг хариуцан гаргаж хэвлүүлсэн.</p> <p>-Шууд удирдлага байсан: Зохиолч, Б.Шүүдэрцэцэг [REDACTED]</p> <p>-Хамт ажиллаж байсан: -Дуучин Д.Отгонжаргал, [REDACTED] -Зураач Л.Батбилэг, [REDACTED]</p>
3.3	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>Үгүй</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

4.1	<p>Хууль зүйн өндөр мэргэшил</p> <p>Миний бие Б.Оюунгэрэл нь Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч, бакалавр мэргэжлээр төгсөж, улсад 16 жил, төрийн албанд 14 жил үүнээс шүүхийн салбарт 11 жил 08 сар тасралтгүй ажиллаж байна.</p> <p>Ажлын гараагаа гүйцэтгэх эрх мэдлийн салбар буюу Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эхэлсэн бөгөөд улмаар хувийн салбарт болон Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны төв байгууллага буюу Шүүхийн ерөнхий зөвлөлд Зохион байгуулагчаас эхлээд, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, Шүүгчийн туслах, Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, Бодлого төлөвлөлт, Хууль зүйн асуудлыг тус тус хариуцан гардан ажиллаж шүүхийн шүүн таслах ажиллагааны болон шүүхийн захиргааны мэдлэг, туршлага хуримтлуулсан, төрийн албаны мерит зарчмын дагуу дэвшсэн, мэргэшсэн төрийн жинхэнэ албан хаагч юм.</p> <p>Өнгөрсөн хугацаанд төрийн албаны төрийн үйлчилгээний албан тушаалаас эхлээд төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн албан тушаалд тасралтгүй ажиллаж үүнээс шүүх эрх мэдлийн салбарт шүүн таслах ажиллагааны чиглэлээр зохион байгуулагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслах, шүүхийн захиргааны чиглэлээр шүүхийн захиргааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлого, төлөвлөлт, хууль зүйн чиглэлээр</p>
-----	--

	<p>ажиллаж хуримтлуулсан дадлага, туршлагаа хууль зүйн өндөр мэргэшилтэй гэж үзэж байна.</p> <p>Мөн 2016 оноос хойш миний бие Шүүхийн ерөнхий зөвлөлийн 3 удаагийн бүрэлдэхүүн, ажлын албаны удирдлагуудаас тухай бүр суралцсан туршлага болон шүүх эрх мэдлийн салбарын шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, шүүх эрх мэдлийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх, өмнөх хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг үнэлэх, шинээр боловсруулах, батлуулах ажилд тогтвортой, туушдаа, үр дүн гаргаж, гар бие оролцсон байдал тус албан тушаалд ажиллахад давуу тал болно гэж үзэж байна.</p> <p>Миний ажлыг үнэлж Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019, 2022, 2024 оны шилдэг ажилтан, 2022 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, 2025 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүндэт тэмдэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хүндэт жуухаар тус тус шагнаж байсан.</p> <p>1.Хуулийн төсөл боловсруулах, ажлын хэсэгт ажилласан үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр: -Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байсан Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх шүүгч Л.Энхбилэг, [REDACTED] -Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, [REDACTED]</p> <p>2.Бодлого, төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр: -Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга байсан одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүн Р.Батрагчаа, [REDACTED] -Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны дарга байсан Р.Онончимэг, [REDACTED]</p> <p>3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: -Шууд удирдлага Захиргааны удирдлага, бодлогын газрын дарга байсан: Шууд удирдлага: Ж.Сайнхишиг, [REDACTED] sainkhisig115@gmail.com</p> <p>4.Шүүн таслах ажиллагааны чиглэлээр үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр: -Шүүгч байсан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Зориг, [REDACTED] -Ерөнхий шүүгчийн туслах байсан Н.Мөнхгэрэл, [REDACTED] Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга.</p> <p>Орчуулга, ажлын хэсгийн тушаал, боловсруулж батлуулсан дүрэм, журам, бодлогын баримт бичгийг хавсаргав.</p>
4.2	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>Орчуулга ном: (Хэвлэгдсэн)</p> <p>-Шүүхийн хараат бус байдал-Judicial independence, Олон Улсын баримт бичиг эмхэтгэл 2019 он, Шүүхийн ерөнхий зөвлөл номын “13.Шударга ёс ба мэдээллийн технологийн тухай Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2011 оны 14 дүгээр зөвлөмж”, “15.Шүүгч ба хуульчийн харилцааны талаарх Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2013 оны 16 дугаар зөвлөмж” хэсгийг тус тус орчуулсан.</p>

Боловсруулсан хуулийн төслийн санал: (Доорх хуулийн болон бодлогын баримт бичиг, дүрэм журмыг боловсруулсан баримтууд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн архивын хадгаламжийн нэгжид анхны төсөл, явуулсан албан бичиг, тушаал, тогтоол түүнийг боловсруулсан, хянасан ажилтан, албан хаагчдын нэр, гарын үсгээр хадгалагдаж байгаа болно.)

1.УИХ-2024.06.05: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Засгийн газарт хүргүүлсэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ төслийн саналын Үзэл баримтлал, хуулийн төсөл, Танилцуулга, хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эхний төслийг боловсруулсан.

/Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын хэсгийн нарийн бичиг, архивт баримтууд хадгалагдсан/

2.УИХ-2024.06.05: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Засгийн газарт хүргүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналын шүүгчийн цалин, зэрэг дэв, шүүхийн захиргааны байгууллагын цалин хэсэг, тус хуулийг дагаж мөрдөх процессын хуулиуд дахь цахимаар явуулж болно гэсэн хэсэг/ШЕЗ-ийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дэд ажлын хэсгийн гишүүн/

Боловсруулсан бодлогын баримт бичиг:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 148 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн захиргааны байгууллагын 2024-2027 стратеги төлөвлөгөө”-ний анхны төсөл-хүчинтэй,

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого” хүчинтэй,

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх шалгуур үзүүлэлт” хүчинтэй,

Боловсруулсан дүрэм, журам:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам”-хүчинтэй,

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах журам” хүчинтэй,

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “Ажлын албаны нэгжүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэл”,

4.Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны А/63 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн захиргааны удирдлагын чиглэлийн хууль тогтоомж, шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ

	<p>үнэлгээ хийх ажлын жагсаалт, аргачлал”, “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээний маягт”,</p> <p>Боловсруулсан тайлан:</p> <p>-Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий Монгол Банкны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Хууль сахиулах ажлын хэсэг болон Монгол Улс ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсонтой холбогдуулан түүнээс гарах ажлын хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийг төлөөлөн оролцож, 2020 онд БНХАУ-д Монгол Улсын тайлан хамгаалах багт ажилласан. Ингэхдээ анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолоос 2017-оос 2020 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн, буцаасан, ажиллагаанд байгаа мөнгө угаах, татвараас зайлсхийх төрлийн гэмт хэргийн дэлгэрэнгүй тоон мэдээлэл, дүн шинжилгээг гаргаж, тайланд нэгтгэсэн.</p> <p>-Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрдлийн үнэлгээний хувьсагч-9, 10-ын 2026 оны тайланг хүргүүлсэн.</p>
4.3	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ)</p> <p>Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</p> <p>Монгол Улсын Их Сургуул-Хууль зүйн сургуулийн Бакалавр, диплом №D201021084, Эрх зүйч</p>
4.5	<p>Сахилгын шийтгэл</p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт зэрэг нийт 168 хуудастай.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Баатарсүрэн

Өөрийн нэр: Оюунгэрэл

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

---oOo---